ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2022/84/СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Төрийн аудитын газрын<br>тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Дагвасүрэн<br>Утас: 99014227<br>Цахим хаяг: dagvasurend@audit.gov.mn<br><br>Аудитор: Г.Баасанжаргал<br>Утас: 99032514<br>Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
3. Аудитын тайлан....8
3.1 Ерөнхий зүйл....8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....9
3.4 Материаллаг байдал ....9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....10
3.8 Аудитын гол асуудал ....10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....11
4. Аудитын илрүүлэлт ....11
4.2.1 Залруулсан алдаа .... 11
4.2 .2 Төлбөрийн акт .... 11
4.2.3 Албан шаардлага .... 11
4.2.4 Зөвлөмж.... 11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2022.02.24 № 1302/254

танай ____________ -ны № ______________ -т

ЯРУУ СУМЫН ЕБС-н
ЗАХИРАЛ Б.ЦЭНД-АЮУШ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013025215

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **73,058,118.00** | **58,529,502.00** |
| **33** | **АВЛАГА** | 482,035.00 | 58,380.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 482,035.00 | 58,380.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 72,576,083.00 | 58,471,122.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 7,291,564.00 | 6,464,664.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,512,664.00 | 5,512,664.00 |
| 35130 | Эм боох материал | 1,778,900.00 | 952,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,744,590.00 | 551,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 62,539,929.00 | 51,454,958.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,482,659.00 | 4,448,847.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 33,442,989.00 | 33,646,207.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,594,859.00 | 2,280,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 648,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,041,660.00 | 4,874,374.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,977,762.00 | 5,557,530.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **261,627,346.83** | **251,528,240.81** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 261,627,346.83 | 251,528,240.81 |
| **392** | **Биет хөрөнгө** | 166,491,971.83 | 156,805,365.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 262,236,387.00 | 262,236,387.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -158,833,988.87 | -160,996,065.35 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 8,240,000.00 | 8,240,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -8,240,000.00 | -8,240,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 103,604,261.65 | 101,945,770.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -94,296,898.29 | -88,900,320.88 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,815,693.20 | 49,231,091.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -29,063,754.94 | -36,274,635.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 42,432,900.00 | 35,877,300.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -25,676,903.29 | -21,906,636.73 |
| 39217 | Ном | 15,274,275.37 | 15,592,475.37 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 95,135,375.00 | 94,722,875.00 |
| 39301 | Програм хангамж | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -790,625.00 | -1,203,125.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 93,726,000.00 | 93,726,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **334,685,464.83** | **310,057,742.81** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **334,685,464.83** | **310,057,742.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 334,685,464.83 | 310,057,742.81 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 267,428,455.62 | 267,428,455.62 |
| 51101 | Өмч: - төрийн | 267,428,455.62 | 267,428,455.62 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -139,863,452.91 | -157,935,574.93 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -139,863,452.91 | -133,307,852.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -24,627,722.02 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 207,120,462.12 | 200,564,862.12 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **334,685,464.83** | **310,057,742.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **492,753,644.00** | **467,460,060.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,499,000.00** | **8,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,499,000.00 | 8,000,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,499,000.00 | 8,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,499,000.00 | 8,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **464,116,244.00** | **459,460,060.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 452,784,200.00 | 428,659,760.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 452,784,200.00 | 428,659,760.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 25,138,400.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 11,332,044.00 | 30,800,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 11,332,044.00 | 30,800,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **593,038,108.79** | **491,655,691.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **593,038,108.79** | **491,655,691.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 566,589,321.79 | 480,489,946.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 359,832,058.00 | 353,198,655.00 |
| 210101 | Үндсэн цалин | 253,821,191.00 | 241,198,655.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,572,235.00 | 92,273,600.00 |
| 210104 | Урамшуулал | 27,438,632.00 | 19,726,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,173,074.00 | 45,256,520.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,712,842.00 | 31,878,264.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,498,142.00 | 3,512,327.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,798,514.00 | 2,813,547.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 651,234.00 | 641,126.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,512,342.00 | 6,411,256.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,563,586.00 | 31,851,755.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,107,500.00 | 3,765,996.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,376,086.00 | 27,465,759.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,080,000.00 | 620,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,007,340.00 | 14,408,990.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 633,260.00 | 1,350,110.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,672,600.00 | 1,606,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,800,000.00 | 730,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 35,400.00 | 211,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 62,900.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 803,180.00 | 502,770.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 10,007,610.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 11,882,290.00 | 12,602,411.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 403,500.00 | 4,519,990.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,478,790.00 | 8,082,421.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 2,352,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,352,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,500,000.00 | 494,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.00 | 494,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 530,300.00 | 864,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 380,300.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 864,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 119,100,673.79 | 19,460,815.76 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,472,300.00 | 2,011,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 116,628,373.79 | 17,449,015.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,448,787.00 | 11,165,745.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 10,946,543.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 10,946,543.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,502,244.00 | 7,946,015.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 3,670,200.00 | 7,246,015.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 11,332,044.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 3,219,730.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,219,730.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-100,284,464.79** | **-24,195,631.76** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 432,090.26 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 432,090.26 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -432,090.26 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-100,284,464.79** | **-24,627,722.02** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **267,428,455.62** | **207,120,462.12** | **-139,863,452.91** | **00.00** | 334,685,464.83 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **267,428,455.62** | **207,120,462.12** | **-139,863,452.91** | **00.00** | 334,685,464.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 6,555,600.00 | 00.00 | 6,555,600.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **267,428,455.62** | **207,120,462.12** | **-133,307,852.91** | **00.00** | 341,241,064.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -6,555,600.00 | 00.00 | 00.00 | -6,555,600.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -24,627,722.02 | 00.00 | -24,627,722.02 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **267,428,455.62** | **200,564,862.12** | **-157,935,574.93** | **00.00** | 310,057,742.81 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **489,254,644.00** | **459,460,060.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **489,254,644.00** | **459,460,060.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 452,784,200.00 | 428,659,760.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 452,784,200.00 | 428,659,760.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 25,138,400.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 11,332,044.00 | 30,800,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 11,332,044.00 | 30,800,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **485,104,644.00** | **458,606,860.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **485,104,644.00** | **458,606,860.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **455,540,467.00** | **449,036,380.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 360,314,093.00 | 352,775,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 254,142,440.00 | 241,752,067.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,733,021.00 | 91,296,533.00 |
| 210104 | Урамшуулал | 27,438,632.00 | 19,726,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,173,074.00 | 45,256,520.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,712,842.00 | 31,878,264.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,498,142.00 | 3,512,327.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,798,514.00 | 2,813,547.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 651,234.00 | 641,126.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,512,342.00 | 6,411,256.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,138,400.00 | 27,340,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,107,500.00 | 4,569,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,950,900.00 | 22,150,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,080,000.00 | 620,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,696,900.00 | 4,185,560.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 530,100.00 | 709,160.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,270,600.00 | 1,606,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,800,000.00 | 800,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 35,400.00 | 211,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 62,900.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,997,900.00 | 857,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,615,400.00 | 9,733,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,182,400.00 | 1,500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,072,500.00 | 7,872,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,360,500.00 | 360,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,500,000.00 | 494,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.00 | 494,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 530,300.00 | 864,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 380,300.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 864,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,572,300.00 | 5,386,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,572,300.00 | 5,386,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,564,177.00** | **9,570,480.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 10,946,543.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 10,946,543.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,617,634.00 | 6,350,750.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,785,590.00 | 5,650,750.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 11,332,044.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 3,219,730.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 3,219,730.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,150,000.00** | **853,200.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,150,000.00** | **853,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,150,000.00** | **853,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,150,000.00 | 853,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,150,000.00 | 853,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-4,150,000.00** | **-853,200.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 454,144,700.00 | 451,542,670.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 454,144,700.00 | 451,542,670.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 444,979,700.00 | 445,191,920.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 350,633,300.00 | 352,775,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 238,633,300.00 | 241,752,067.00 |
| 210102 | Нэмэгдэл | 92,273,600.00 | 91,296,533.00 |
| 210104 | Урамшуулал | 19,726,400.00 | 19,726,400.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,335,400.00 | 45,256,520.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,310,200.00 | 31,878,264.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,506,300.00 | 3,512,327.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,805,100.00 | 2,813,547.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 701,200.00 | 641,126.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,012,600.00 | 6,411,256.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,340,300.00 | 27,340,300.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,569,400.00 | 4,569,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,150,900.00 | 22,150,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 620,000.00 | 620,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,348,000.00 | 4,455,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 553,400.00 | 661,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,606,600.00 | 1,606,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 800,000.00 | 800,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 530,100.00 | 530,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 857,900.00 | 857,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,691,600.00 | 9,733,400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 1,500,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,331,100.00 | 7,872,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 360,500.00 | 360,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 494,800.00 | 494,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 494,800.00 | 494,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 864,000.00 | 864,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 864,000.00 | 864,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1272300.00 | 1272300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,272,300.00 | 1,272,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9165000.00 | 6350750.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,165,000.00 | 6,350,750.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,465,000.00 | 5,650,750.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 700,000.00 | 700,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 454,144,700.00 | 454,762,400.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 423,344,400.00 | 423,962,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 423,344,400.00 | 423,962,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,800,300.00 | 30,800,300.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,800,300.00 | 30,800,300.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 30.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 23.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 06.00 | 06.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **4,697,660.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **4,697,660.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 4,697,660.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 48,160.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 48,160.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 4649500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 4,649,500.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар товч тодорхойллоо. Үүнд:

Зорилго: Багш сурагчдын харилцаа хандлага эцэг эхчүүдийн оролцоог сайжруулж хүүхэд нэг бүрийн суурь чадамжийг хөгжүүлж сурлагын чанарт ахиц гаргах.

Зорилт: Сургуулийн орчинд эерэг уур амьсгал бүрдүүлж харилцааны өөрчлөлт гаргах, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлж хамтын ажиллагааг чанаржуулах, хүүхэд нэг бүрийн авьяас чадварыг нээн илрүүлэх, сургалтын таатай орчин бүрдүүлэх.

Чиг үүрэг: Ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын тухай хуулийн 43.1.2-"79.5, 79.6-д" гэснийг "99.5, 99.6-д" гэж өөрчилсүгэй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 467,460.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,011.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,258.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 482.00 | 58.40 | (423.60) |
| Бараа материал | 72,576.10 | 58,471.10 | (14,105.00) |
| Үндсэн хөрөнгө | 261,627.30 | 251,528.20 | (10,099.10) |
| **Нийт хөрөнгө** | **334,685.40** | **310,057.70** | **(24,627.70)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Өздийн өмч/ | 334,685.40 | 310,057.70 | (24,627.70) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **334,685.40** | **310,057.70** | **(24,627.70)** |

Авлага дансны үлдэгдэл 423.6 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой авлагыг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 14,105.0 мянган төгрөгөөр буурсан нь материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,099.1 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 24,627.7 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 458,842.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 458,842.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 428,659.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,800.3 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авч, урсгал үйл ажиллагаанд 458,606.8 мянган төгрөгийг зарцуулж, 3,219.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.m цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,218.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 318.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 473.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,427.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 4.2.1 Залруулсан алдаа

Тайлант онд худалдан авсан номыг үр дүнгийн тайлангийн хөрөнгийн зардалд тусгаагүй 318.2 мянган төгрөгийг аудитын явцад залруулсан.

### 4.2 .2 Төлбөрийн акт

Сургуулийн захирал, нягтлан бодогч нарын цалин, амралтын мөнгө давхардсан 473.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

### 4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Төсвийн аривлан хэмнэлттэй холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u>

*2020 онд нийлүүлэгдсэн “Си-Ти-Эс” ХХК-аас 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг одоог хүртэл ашиглаагүй байна.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй бөгөөд тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

<u>*Өгсөн зөвлөмж*</u>*:*

*“Си-Ти-Эс” ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн програмыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх.*

2 НББ, тайлагналтай холбоотой асуудал

<u>*Илрүүлэлт:*</u>

*Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргаагүй, гүйлгэн зарцуулсан 3,127.0 мянган төгрөгийн зөрчил байна.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:*

*Батлагдсан төсвийг Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалар батлагдсан “зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу зарцуулж, тайлагнах.*

3 НББ, тайлагналтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

*Харилцагч байгууллага болон иргэнд төлсөн төлбөрийн баримтгүй /и-баримт/ ажил гүйлгээ гаргасан 8,650.0 мянган төгрөн байна.*

*Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

*Өгсөн зөвлөмж:*

*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | | 5 | 14,218.3 | 1 | 318.2 | 1 | 473.1 | | | 3 | 13,427.0 |
| Дүн | | 5 | 14,218.3 | 1 | 318.2 | 1 | 473.1 | | | 3 | 13,427.0 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | | | | |

**БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:**

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА 2022.02.25

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН 2022.02.25

**БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР Г.БААСАНЖАРГАЛ 2022.02.25